



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/258

Арвайхээр

**Зүүнхайрханыг тайх, тахилга үйлдэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны “Зүүн хайрхан уулыг тахилгатай болгох тухай” 89 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зүүнхайрхан уулын тэнгэрийг тайх ёслолыг 2019 оны 5 дугаар сарын 12-ний өдөр үйлдсүгэй.

2. Уулыг тайх тахилгын ёслолын арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ганболд-аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Нарийн бичгийн дарга: П.Мөнхзул-аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд: М.Дэлгэрсайхан-аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга

Х.Нямцэрэн –аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

Б.Энхтөр-аймгийн Засаг даргын дэргэдэх Биеийн тамир спортын газрын дарга

С.Цэдэнбалжир-аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

О.Ганбат-аймгийн Цагдаагийн газрын дарга

Д.Түмэнжаргал-аймгийн Хөгжимт драмын театрын дарга

Я.Ганзаяа-“Ганданпунцаглин” хийдийн хамба лам

Д.Мөнхбаяр-Есөнзүйл сумын Засаг дарга

Ё.Рэнцэндорж-Өлзийт сумын Засаг дарга

Г.Баярмөнх-Бүрд сумын Засаг дарга

Т.Баярмөнх-Хужирт сумын Засаг дарга

Э.Насанцогт-Баян-Өндөр сумын Засаг дарга

С.Дамдинпүрэв- Сант сумын Засаг дарга

Б.Ууганбаяр-Зүүнбаян-Улаан сумын Засаг дарга

А.Мөнхбат-Баянгол сумын Засаг дарга

Б.Нацаг-аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны дарга

О.Цэрэнчимэд –аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

3. Зүүнхайрхан уулын тахилга үйлдэх бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган, тахилгын арга хэмжээг хүн зоны сэтгэлд нийцсэн, ёслол хүндэтгэлтэйгээр зохион байгуулахыг Ажлын хэсэг (Ц.Ганболд)-т даалгасугай.

4. Тахилга ёслолын арга хэмжээнд шаардагдах 15.000.000 (арван таван сая) төгрөгийг үндсэн чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД